

“БАЯНХОНГОР-АЛТАЙ ЧИГЛЭЛИЙН 126.7 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМ ТӨСӨЛ”-ИЙН КОНЦЕССЫН ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ГЭРЭЭ

2020 оны 2 дугаар
сарын 13-ны өдөр

Улаанбаатар
хот

“Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ (цаашид “Нэмэлт гэрээ” гэх)-г Концессын тухай хуулийн 23.1 дэх заалт, “Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн концессын гэрээний 2.23 дахь заалт, “Макс рөүд” ХХК-ийн 2020 оны 1/36, 1/52 дугаар албан тоот хүсэлтүүдийг тус тус үндэслэн нэг талаас Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар /цаашид “Эрх бүхий этгээд” гэх/-ын дарга Б.Баярсайхан;

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Макс рөүд” ХХК, түүнийг төлөөлж захирал Ч.Батбаяр /цаашид “Концесс эзэмшигч” гэх/ нар дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож энэхүү концессын нэмэлт гэрээг 2020 оны 2 дугаар сарын 13-ны өдөр байгуулав.

НЭГ. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

1.1. “Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн концессын гэрээний 1.7 дахь заалтын “2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө” гэснийг “2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө” гэж өөрчлөн найруулав.

1.2. “Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн концессын гэрээний 1.5.2 дахь заалтыг хасав.

ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ

2.1. “Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто зам төсөл”-ийн концессын гэрээнд энэхүү концессын нэмэлт гэрээгээр нэмэлт, өөрчлөлт оруулсан заалтуудаас бусад концессын гэрээ болон концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай гэрээний заалтууд нь хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

2.2. Энэхүү концессын нэмэлт гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар гэрээ байгуулагдсанд тооцох бөгөөд концессын гэрээний салшгүй хэсэг байна.

2.3. Энэхүү нэмэлт гэрээг адил хүчинтэй 4 хувь үйлдсэн бөгөөд концессын гэрээний хугацаанд хүчинтэй байна.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

**ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

Гарын үсэг:

Нэр: Б.Баярсайхан
Албан тушаал: Үндэсний хөгжлийн
газрын дарга
Тамга:



**КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ
ТӨЛӨӨЛЖ:**

Гарын үсэг:

Нэр: Ч.Батбаяр
Албан тушаал: Макс рөүд ХХК-ийн
захирал
Тамга:

